



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 4/234

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 04 тоот Тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн “Монгол Улсын Их Сургуульд зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын Их Сургуулийн Хүндэт цол олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2015 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. “Монгол Улсын Их Сургуульд зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам”, “Монгол Улсын Их Сургуулийн Хүндэт цол олгох журам”-ыг чанд мөрдөн ажиллахыг бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирал /Ж.Эрдэнэбулган, Н.Батнасан, С.Баттулга, Н.Баатарбилэг, Б.Баяртгтох, Д.Намжил, Н.Эрдэнэчимэг/ нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний албаны дарга /В.Батцэнгэл/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

3.3. Эмерит профессор нь МУИС-ийн дэд бүтцийг ашиглан эрдэм шинжилгээний бие даасан санхүүжилттэй дотоод, гадаадын төсөл хэрэгжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй бөгөөд гадаадад эрдэм шинжилгээний хуралд оролцоход санхүүгийн зохих дэмжлэг авах, сургууль, тэнхимийн саналаар ажлын хэсэг, шалгалтын комисс, зөвлөх багт ажиллах, шаардлагатай бусад уйл ажиллагаанд оролцох, хоёр жилд нэг удаа мөнгөн тусламж авах, мөн түүнчлэн сургуулийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд уригдах эрхтэй.

ДӨРӨВ. ХҮНДЭТ ЦОЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 4.1. Хүндэт цолд нэр дэвшигчийн үндсэн харьяа байгууллагын албан тодорхойлолт, танилцуулга
- 4.2. Хүндэт цолд нэр дэвшигчийн бүтээлийн жагсаалт, гол бүтээлүүд, тэдгээрийн товч танилцуулга
- 4.3. Хүндэт цолд нэр дэвшүүлэгч байгууллага, харьяалах бүрэлдэхүүн факультет, сургуулийн эрдмийн зөвлөлийн болон тэнхимийн хурлын тэмдэглэл, шийдвэр
- 4.4. Хүндэт цолд нэр дэвшигчийн эрдмийн зэрэг, цолыг баталсан албан ёсны үнэмлэх, диплом, тэдгээрийн баталгаат хуулбар
- 4.5. Эмерит профессор цолд нэр дэвшигчийг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл хэлэлцэн шийдвэр гаргаж, улмаар МУИС-ийн Эрдмийн зөвлөлд уламжилна.

ТАВ. ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ

- 5.1. МУИС-ийн хүндэт доктор, хүндэт профессор цол, эмерит профессор олгох эсэхийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар, салбарын хүндэт доктор цолыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.2. МУИС-ийн “Хүндэт доктор”, “Хүндэт профессор” цол хүртсэн иргэнд үнэмлэх, зүүлт гардуулж, өмсгөл өмсгөнө. “Эмерит профессор” цол хүртсэн иргэнд энгэрийн тэмдэг, диплом гардуулна. Хүндэт цол хүртэгсдэд МУИС-ийн үнэмлэх олгоно.
- 5.3. Бүрэлдэхүүн сургуулийн хүндэт доктор цол хүртсэн иргэнд үнэмлэх, МУИС-ийн хүндэт медаль гардуулна.
- 5.4. Хүндэт цол хүртсэн иргэнд олгох батламжийг (үнэмлэх, диплом, зүүлт, өмсгөл, хүндэт медаль) тус тусын Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар албан ёсоор, гүн хүндэтгэлтэйгээр гардуулна.
- 5.5. МУИС-ийн Хүндэт цол хүртэгсэд Эрдмийн дугуй тэнхимд эрдэмтэн багш, судлаач, суралцаагчдад зориулан лекц уншина.
- 5.6. Хүндэт цол хүртсэн иргэн МУИС-ийн хүндэтгэл хүлээнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Өмнөх журмаар МУИС-ийн хүндэт, профессор цол хүртэгсдэд шинэчилсэн журмын заалт хамаarahгүй.



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД
ЗӨВЛӨХ, ГЭРЭЭТ БА ЗОЧИН ПРОФЕССОР,
ЦАГИЙН БАГШ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. МУИС-д зөвлөх, гэрээт, зочин профессор, дэд профессор, цагийн багш ажиллах, ажиллуулах харилцааг уг журмаар зохицуулна.
- 1.2. Гэрээт профессор, гэрээт дэд профессор, зочин багш, зочин профессор, цагийн багшаар ажиллах иргэн “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын 5.4-т заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 1.3. Гэрээт профессор, гэрээт дэд профессор, зочин багш, зочин профессор, цагийн багш нь МУИС-ийн захиргааны болон дотоод үйл ажиллагаанд оролцохгүй.

ХОЁР. ЗӨВЛӨХ ПРОФЕССОР

- 2.1. МУИС-д профессор, дэд профессорын зэрэглэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, улмаар Монгол улсын хөдөлмөрийн хуулийн зохих журмын дагуу тэтгэврээ тогтоолгосон эрдэмтэн багшийг тухайн тэнхимийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын зэрэглэлд 5 хүртэл жил ажиллуулж болно. Зөвлөх профессор нь мэдлэг чадвараа өвлүүлэн үлдээх, залуу судлаачдыг бэлтгэн сургах, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зөвлөх үүрэгтэй. Зөвлөх профессор, зөвлөх дэд профессорын гүйцэтгэх эрдэм шинжилгээ, сургалтын цагийн хэмжээг гэрээнд тусгана. МУИС-д олон жил үр бүтээлтэй ажилласан, сургалт, судалгааны тодорхой аргазүй эзэмшсэн, нарийн ховор мэргэжлээр мэргэшсэн ахлах багшийг тэтгэвэр тогтоолгосны дараа харьяалах тэнхимд нь цагийн ачаалал байгаа тохиолдолд нэг жилийн хугацаатай ажиллуулж болох ба гүйцэтгэх ажлыг мэн гэрээнд заана.
- 2.2. Зөвлөх профессор, зөвлөх дэд профессороор ажиллах багш дараах болзлыг хангасан байна. Үүнд:
 - Эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцох боломжтой;
 - МУИС болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 5-аас доошгүй жил МУИС-д ажиллаж байгаад тэтгэвэр тогтоолгосон;
 - Бакалаврын болон магистрант, докторантад мэргэжлийн хичээл заадаг, магистрант, докторантын ажлыг удирдаж, судалгааны семинар явуулдаг;

- Судалгааны арга барил эзэмшүүлэх, заах арга зүйн чиглэлээр залуу багш нарыг дагалдуулан сургадаг;
 - Зөвлөх профессор нь сургалт, судалгааны ажилд удирдаж буй магистрант, докторантуудаа хамруулах, туслах ажилтнаар ажиллуулдаг байх, тэдэнд дадлагажих, мэргэшихэд дэмжлэг үзүүлдэг байх
- 2.3. Зөвлөх профессор, зөвлөх дэд профессортой нэг жилийн хугацаатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний биелэлт, үр дүнг харгалzan хугацааг сунгаж болно.

ГУРАВ. ГЭРЭЭТ ПРОФЕССОР

- ШУА болон бусад эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, үйлдвэрлэлийн байгууллагад ажилладаг, докторын зэрэгтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, профессор, дэд профессорын зэрэглэлд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан мэргэжилтнийг МУИС-д гэрээт профессор, гэрээт дэд профессор зэрэглэлд хавсруулан ажиллуулж болно. Докторын зэрэггүй иргэнийг гэрээт багшаар ажиллуулахгүй.
- Гэрээт профессор, гэрээт дэд профессор зэрэглэлд ажиллах эрдэмтэдтэй, бүрэлдэхүүн сургуулийн тэнхим, захиргааны зөвлөлийн саналыг үндэслэн гүйцэтгэх ажил үүрэг, цалин хөлс, хөдөлмөрлөх нөхцөл, бусад харилцааг нарийвчлан заасан гэрээ байгуулна. Гэрээг хагас жилийн болон бүтэн жилийн хугацаатай байгуулж болно.
- Шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэр тогтоолгосон, докторын зэрэгтэй, профессорын болон дэд профессорын зэрэглэлд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан мэргэжилтнийг МУИС-д 2 жил хүртэл хугацаагаар гэрээт профессор, гэрээт дэд профессороор ажиллуулж болно.
- Гэрээт багшаар, МУИС-ийн төсвөөс бус, харин өөр эх үүсвэрээр цалинжиж буй МУИС-ийн орон тооны бус докторын зэрэгтэй гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, дадлага, туршлагатай мэргэжилтнийг ажиллуулж болно. МУИС-д үндсэн орон тоогоор ажиллаж буй удирдах албан тушаалтан, эрдэм шинжилгээний болон бусад ажилтан гэрээт багшаар ажиллахыг хориглоно.


ДӨРӨВ. ЗОЧИН ПРОФЕССОР

- МУИС-ийн болон гадаадын их сургууль, байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны гэрээний хүрээнд нарийн мэргэшсэн, оюуны өндөр чадавхитай мэргэжилтнийг зочин багш, зочин профессор зэрэглэлд урьж ажиллуулж болно.
- Зочин багш, зочин профессор урих, ажиллуулах талаарх тэнхимиийн санал, уг саналыг хэлэлцсэн бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэр зэрэгт үндэслэн, бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал МУИС-ийн Гадаад харилцааны хэлтэст зочин багш, зочин профессор урих, ажиллуулах хүсэлтийг бичгээр уламжилна.

- 4.3. МУИС-ийн урилгаар ирсэн гадаад багшийг эрдмийн зэрэг цолыг нь харгалзан зочин багш, зочин профессорын орон тоонд ажиллуулах бөгөөд гэрээнд тусгайлан заагаагүй тохиолдолд холбогдох тэнхим, бүрэлдэхүүн/салбар сургуулийн санал, эрдмийн зэрэг, цол, ажилласан жил зэргийг харгалзан үзэж, зохих зэрэглэлийн цалин, нэмэгдлийг олгоно.
- 4.4. Байр, орон сууцаар хангах, дотоод томилолтын зардал, нэмэлт цалин урамшуулал олгох, судалгааны ажилд нь дэмжлэг үзүүлэх болон бусад асуудлыг гэрээгээр зохицуулна.

ТАВ. ЦАГИЙН БАГШ

- 5.1. Тухайн хөтөлбөрөөр сургалт эрхлэхэд нарийн мэргэшлийн багш дутагдалтай тохиолдолд гэрээгээр цагийн багш ажиллуулж болно. Цагийн багш нь МУИС-ийн багшид тавигддаг нийтлэг шаардлагыг хангасан, багшлах дадлага туршлагатай, магистраас доошгүй зэрэгтэй мэргэжилтэн байвал зохино.
- 5.2. МУИС-ийн захирлын тушаалаар цагийн багш ажиллах шийдвэр гарах бөгөөд цагийн багштай холбогдох гэрээг мэргэжлийн тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирал байгуулна.
- 5.3. МУИС-ийн захирал, дэд захирал, алба, хэлтсийн дарга зэрэг удирдах албан тушаалтан мэргэжлийн чиглэлээрээ оюутан суралцагчдад хичээл зааж болох ба энэ тохиолдолд цагийн багшийн адил захирлын тушаалаар шийдвэрлэнэ.



МУИС-ийн захирлын 2015 оны 08-р сарын 25-ны
өдрийн 2 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УХД0072 9104399

МУИС-ИЙН ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

МУИС-ийн Эрдмийн Зөвлөлөөс МУИС-ийн хүндэт цол олгоход уг журмыг дагаж мөрдөнө.

МУИС-ийн хүндэт цол нь МУИС-ийн, Бүрэлдэхүүн сургуулийн гэсэн хоёр төрөл байна.

НЭГ. МУИС-ИЙН ХҮНДЭТ ЦОЛ

- 1.1 МУИС-ийн хүндэт цол нь “Хүндэт доктор”, “Хүндэт профессор”, “Эмерит профессор” байна.
- 1.2 Хүндэт доктор цолыг шинжлэх ухаан, соёл, боловсролыг хөгжүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, энх тайван, хүмүүнлэг, төр, олон нийтийн салбарын нэрт зүтгэлтэн гадаадын иргэнд,
- 1.3 Хүндэт профессор цолыг МУИС-ийн хөгжил, дэвшилд оруулсан гавьяа зүтгэл, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлын техник технологийн шинэчлэлд оруулсан үнэтэй хувь нэмэр зэргийг үнэлж, гадаадын эрдэмтэнд,
- 1.4 Эмерит профессор цолыг МУИС-д ажиллах хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон, журамд заасан шаардлагыг хангасан зөвлөх профессорт тус тус олгоно.

ХОЁР. БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ЦОЛ

- 2.1. Бүрэлдэхүүний сургуулийн хүндэт цол нь салбарын “Хүндэт доктор” байна.
- 2.2. Бүрэлдэхүүний сургуулийн хүндэт доктор цолыг шинжлэх ухааны тухайн салбарт эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлын техник технологийн шинэчлэлд жинтэй хувь нэмэр оруулсан, өөрийн шавь сургалт, дэг сургуулийг буй болгосон, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх үйлсэд асар их үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн, төр, нийгэм, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, дэмжигч дотоод, гадаадын иргэнд олгоно.

ГУРАВ. ЭМЕРИТ ПРОФЕССОР

- 3.1. МУИС-ийн профессор, дэд профессор цолтой, тус сургуульд 20-аас доошгүй жил профессорын албан тушаалд ажилласан, шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх үйлсэд дорвitoй хувь нэмэр оруулсан эрдэмтэнд Эмерит профессор цол олгоно.
- 3.2. Эмерит профессор нь МУИС-ийн хөгжилд хувь нэмэр оруулах, гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, МУИС-ийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурийт бэхжүүлэхэд зохих хүчин чармайлт гарган ажиллах үүрэг хүлээнэ.